



Эхэд тооны нэрийг хэрэглэсэн  
учрыг тайлбарлаж, хэлзүйн  
шинж, найруулгын утга үүргийг  
тодорхойлох


# Хичээлийн зорилго



Эхээс тооны  
нэрийг түүж бичих,  
утгаар нь бүлэглэх



Эхэд тооны  
нэрийн утга, хэл  
зүйн онцлогийг  
мэдэх



Эхэд тооны  
нэрийг хэрэглэсэн  
учрыг тайлбарлах



Тооны нэрийг  
найруулгад зөв  
хэрэглэх

# Үйл ажиллагаа 1

Эхээс тоо хэмжээ заасан үгсийг ялган бичээд, асуултын дагуу утгаар нь бүлэглэн бичээрэй.

... Олон улсын “Манга” номын хамгийн том уралдаанд оролцож, 46 улсын 317 бүтээлээс 2015 онд Гран При шагнал хүртэж байв. Зохиолч “Бумбардай” цувралыг даяарчлагдан буй ертөнцөд нүүдлийн соёл, уламжлалт ахуй, өв соёлын онцлогийг авч үлдэх, хойч үедээ уламжлуулах, үндэстний дархлаа тогтоох зорилгоор 2013 оноос эхлүүлсэн...

Хэрэв та хий хоосон өнгөрүүлдэг нэг цагаа уншихад зарцуулбал жилд 100 ном хангалттай уншиж чадна. Дундаж хурдтай хүн цагт 50 хуудас уншдаг . Тэгвэл таныг долоо хоногт 10 хуудас уншдаг гэж тооцвол жилд 26000 хуудас уншина. Ном дундажаар 250 хуудастай гэж үзвэл та жилд 104 ширхэг ном уншина гэсэн үг.

Дээлийн урт мөрнөөс хормой хүртэл 124 см, мөрний өргөн 75 см, хормойн өргөн 90 см. Ханцуй нь нарийн бөгөөд шулуун. Баруун ханцуй нь бараг бүтнээрээ хадгалагдсаныг хэмжихэд урт нь 65 см, суганы хэсэгт өргөн нь 20 см, бугуйн хэсэгт өргөн нь 17 см ажээ. Дээлийн энгэр, хормой, ханцуйн амыг 5 см бор эсгийгээр хөвөөлөн эмжиж, цагаан өнгийн утсаар маш цэвэрхэн хөвөрдөж оёсон. Дээлийн зүүн энгэрт заамаас доош 19 см зайд цагаан өнгөтэй 0,1 см бүдүүн гурван утас нийтгэсэн гурамсан зээгээр сампин зангидсан эр шилбэ хаджээ. Товчны шилбэ 3,5 см, сампингийн голч нь 1,5 см хэмжээтэй...

Жишээ нь: “ Энэхүү бүтээлийг монголын нэрт толь зүйч, төвөд судлаач эрдэмтэн С.Шагж хорьдугаар зууны эхээр буюу 1914 онд бичсэн. 5.4 см урт, 5 см өргөнтэй цаасан дээр төвөд үсгээр, гараар бичсэн хамгийн жижиг ном юм. Бичвэрийн хэмжээ 5 см урт, 4.5 см өргөн, 0,08 мм зузаан, 0.2 грамм жинтэй.” гэсэн хэсэгт байгаа тооны нэрүүд:


Хэд хэчнээн – 1914, 5

Хэдний хэд – 4.5, 0.08, 5.4, 0.2

Хэддүгээр – хорьдугаар ( 20-р , 20 дугаар ) гэх мэтээр бичнэ.

Хэдүүл ?	Хэд хэчнээн?	Хэд орчим ?	Хэдний хэд?	Хэддүгээр ?	Хэд хэдээр?	Хэд дахин?

# Үйл ажиллагаа 2



Дээрх эхэд байгаа үгс ямар асуултад олон хариулагдаж байна вэ?

1

Ихэвчлэн хэд хэчнээн гэсэн асуултад хариулагдаж байна.

Эхэд байгаа тооны нэрийг хасаж уншиж үзэхэд өөрчлөлт гарч байна уу ?

2

Өөрчлөлт гарч байна. Онцлон хэлж байгаа санааг тодруулахад тооны нэрийг өгүүлбэр дотор хаана байрлуулах нь найруулгын чухал үүрэгтэй байдаг.

# Тооны нэрийн утга , асуулт

Үндсэн тооны нэр

Хэд хэчнээн?

Хам тоо

Хэдүүл ?

Тойм тоо

Хэд орчим, Хэдий хэр ?

Дахих тоо

Хэд дахин? Хэдэн удаа ?

Бутархай тоо

Хэдний хэд ?

Дэс тоо

Хэддүгээр ? Хэд дэх?

Түгээл тоо

Хэд хэдээр? Хэдэн ?

# Тооны нэрийн утгын ангилал

Хүн ,амьтан юм үзэгдлийн тодорхой тоо ширхгийг зааж, хэд хэчнээн гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: 1,2,10 ,20, 30

**Үндсэн тоо**

Хүн ,амьтан , юм үзэгдлийн дэс дугаар, дараалал зааж, хэддүгээр, хэд дэх гэсэн асуултад хариулагдана.  
Жишээ нь: 2-р дугаар, 3-р дугаар , тэргүүн, дэд, аман хүзүү

**Дэс тоо**

Хүн, амьтан юм үзэгдлийн хам цугийн утга зааж, хэдүүл гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: Тавуул, арвуулаа, гурвуул

**Хам тоо**

Хүн ,амьтан, юм үзэгдлийн тоо ширхгийг тодорхой бус, барагцаалан заасан, хэд орчим, хэдий хэр гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: арав гаруй, хорь орчим, гуч шахам, дөчөөд гэх мэт

**Тойм тоо**

Нэг төрлийн олон юмыг ижил тэнцүү тоогоор хэсэгчлэн түгээх утгатай, хэд хэдэн, хэд хэдээр гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: арав арав, хоёр хоёроор гэх мэт

**Түгээл тоо**

Үйлийн хэдэн удаа болсныг зааж хэдэн удаа, хэд дахин гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: нэг удаа , хоёр удаа, нэгэнтээ, хоёронтоо гэх мэт

**Дахих тоо**

Бүхэл юмны хувь хэсгийг зааж, хэдний хэд гэсэн асуултад хариулагдана. Жишээ нь: Хоёрны нэг, дөрөвний нэг , тавны нэг гэх мэт

**Бутархай тоо**

# Тооны нэрийн хэлзүйн онцлог

01

## Тооны нэр

Аливаа хүн, амьтан, юмс үзэгдлийн тоо ширхэг, дэс дугаар, хам цуг, бүхэл, бутархай, үйлийн хэдэн удаа болохыг заасан үгс.

02

## Бүтцээр нь

Энгийн ба нийлмэл гэж ангилдаг.

**Энгийн:** нэг язгуур оролцож бүтсэн тооны нэр Жишээ нь: 1, 2, 3, 4, 5

**Нийлмэл:** 2 ба түүнээс дээш энгийн тооны нэр нийлж бүтсэнийг нийлмэл гэнэ.

Жишээ нь: 24, 55, 365, 78

03

## Хэлзүйн хэлбэрээр нь

- Тооны нэрээр тодотгуулж байгаа жинхэнэ нэр олон тооны нөхцөлөөр хэлбэржихгүй
- Үндсээрээ эсвэл жинхэнэ нэрийн үүргээр орсон бол тийн ялгалын нөхцөлөөр аль нэг үгтэй холбогдсон байна.



# Үйл ажиллагаа 3

Дараах хүснэгтэд эхэд байгаа тооны нэрийг түүж бичээд, утгыг тодорхойлоорой.

**Үлгэрлэвэл:** 1973 - үндсэн тоо, үг нийлж бүтсэн гэх мэт

...Хязгааргүй их усан далайд 40 гаруй хоног хөвж 6 дахь тив буюу мөсөн тивд ирлээ. Энд намрын сүүлч болж, агаарын хэм -10 орчим, нар биднээс улам холдсоор. Орон нутаг (Зөвлөлт)-т хориод хүн ажиллах ёстой орон тоонд бид дөрвүүлээ ажиллаж байна. Хоногийн 24 цагт 2-3 цаг унтаж, заримдаа ер унтахгүй ч байна. Биеийн байдал сайн. Өнөөдөр энд 10 цагийн дотор агаарын даралт 20 мб (мөнгөн усны багана)-аар буурахад олонх хүний дуу намсаж, толгой нь өвдлөө. Харин минийх нэг их өвдсөнгүй. Бидний хоол хүнсний хангамж ачсан хөлөг онгоц зуугаад км ойртож ирээд хоёр хонов. Салхи 38 м/с хүрч цасан шуургатай байна. Миний өвөлжих энэ станц үргэлж цас шуурч байдгаараа бусдаасаа онцлог. Өвөлдөө хасах 30-35 хэмээс илүү хүйтрэхгүй боловч салхины хүч их. Агаарын хэм хасах 35 хэм хүрэх үед ч хацар, хамар үлдэхгүй л шинжтэй юм... (Ж.Цэрэндэлэг 1973 оны 11 дүгээр сарын 03 Өмнөд туйл)

№	Тооны нэрийн утга	Тооны нэр, тайлбар
1	Үндсэн тоо	.....
2	Хам тоо	.....
3	Тойм тоо	.....
4	Дахих тоо	.....
5	Бутархай тоо	.....
6	Дэс тоо	.....
7	Түгээл тоо	.....

# Тооны нэрийг найруулгад зөв хэрэглэх

01

Онцлон хэлж буй санааг тодруулахад тооны нэрийн өгүүлбэр дэх байр чухал

02

Тооны нэрийн үндсэн утга салаалж эхэд шинэ санаа бүтээдэг.  
Жнь: түмэн бодол, таван амтай, ерэн хэлтэн, элдэв долоон

03

Тоймлох, бүхэлтгэх, ерөнхийлөх  
\ сарын эхэн, цөөн хэдэн адуу, бүлэг этгээд \

04

Тоолох , тоологдохгүй юм, ганц юмны нэр  
\ гурил , будаа, элсэн чихэр, чих, нар \

05

Дараалсан үндсэн тоог хорших

# Үйл ажиллагаа 4


Монголчууд уртын болон эзлэхүүний хэмжээг гар, хөл болон сав суулгаар хэмждэг.

Монголчуудын уламжлалт заншил, эрхэлдэг аж ахуйн өвөрмөц онцлогийг тусгасан тоо хэмжээ, заасан үгсээс мэдэцгээе.

Сарын газрыг товчлон гүйдэг  
Саахалтын зайтай суудаг  
Аягын чинээ хар овоохой  
Алгын чинээ газраас  
Арван бухал авах  
Хормойн чинээ газраас  
Хорин бухал авах гэх мэт

Сарын газар- сар буюу 30 хоног явах газар  
\ ерөнхийлөн тоймолсон\  
Саахалтын зай – хол ойрын зайг  
баримжаалсан хэмжээ  
Аягын чинээ- маш өчүүхэн  
\ шилжсэн утга \  
Алгын чинээ- маш бага \ шилжсэн утга \  
Арван бухал- 10 ширхэг овоолсон өвс \ их \  
Хормойн чинээ- маш бага \ хэмжээ,  
шилжсэн утга \  
Хорин бухал – 20 ширхэг овоолсон өвс  
\ их \  
\

Зурагт үзүүлсэн тоо хэмжээ заасан үгс болон харгалзах тоон утгуудыг ажиглаад, тэмдэглээрэй.



# Уламжлалт тоо хэмжээ заасан үгсийг тоон утгын хамт мэдэж аваарай.

№	А		№	Б	
1	өвдөгцөө	50-60 см	1	зуур хоногийн газар	21-220 км
2	шилбээр	20-25 см	2	хоногийн газар	120-130 км
3	шагайцаа	0-15 см	3	бүтэн өдрийн газар	90-100 км
			4	хагас өдрийн газар	40-45 км
4	туурайгаар	7-8 см	5	адууны бэлчээр	4-10 км
			6	аргамжааны газар	2-5 км
5	богийн туруу	3 см	7	хонины бэлчээр	1-2,5 км
			8	тугалын бэлчээр	500м –1км
6	бодын туруу	6 см	9	алхам	1 метр

# Монгол гэрийн яс мод болон зай талбайн хэмжээс




Хананы тоо (ш)	Унины тоо (ш)	Тоононы голч шугам (м)	Гэрийн голч шугам (м)	Баганын өндөр (м)	Гэрийн талбай (м <sup>2</sup> )	Гэрийн эзлэхүүн (м <sup>3</sup> )
4	60	1,22	4.90	1.95	18.90	42.70
5	81	1.54	6.10	2.36	29.30	56.50
6	96	1.82	7.30	2.94	42.00	144.10
7	111	2.12	8.50	3.42	57.00	227.50
8	128	2.40	9.60	3.58	72.60	311.50
9	141	2.56	10.20	4.14	79.00	385.40
10	160	3.08	1230	4.97	119.00	699.00
11	173	3.28	1310	5.30	125.00	825.80
12	192	3.64	1450	5.90	165.00	1.182.60



# Бие даан хийх даалгавар

1. Хүснэгтийн 1-р мөрд байгаа А ба Б хэсгийг харьцуулж уншаарай.
2. Ялгаатай зүйл байна уу? А хэсгийн өгүүлбэрүүдэд мэдээлэл ямар байна? Б хэсэгт яаж өөрчлөгдөв? Ажиглаарай.
3. Хүснэгтийн 2 ба 3 -р мөрд дэх А хэсгүүдээс тооны нэрийг хасаж бичээрэй. Өөрчлөлт гарч байна уу? Тайлбарлан бичээрэй.

№	А	Б
1	...Орон нутаг (Зөвлөлт)-т хориод хүн ажиллах ёстой орон тоонд бид дөрвүүлээ ажиллаж байна. Хоногийн 24 цагт 2-3 цаг унтаж, заримдаа ер унтахгүй ч байна. Биеийн байдал сайн. Өнөөдөр энд 10 цагийн дотор агаарын даралт 20 мб (мөнгөн усны багана)-аар буурахад олонх хүний дуу намсаж...	...Орон нутаг (Зөвлөлт)-т хориод хүн ажиллах ёстой орон тоонд бид цөөхүүлээ ажиллаж байна. Хоногт багахан цаг унтаж, заримдаа ер унтахгүй ч байна. Биеийн байдал сайн. Өнөөдөр энд тодорхой хугацааны дотор агаарын даралт буурахад олонх хүний дуу намсаж...
2	Хязгааргүй их усан далайд 40 гаруй хоног хөвж 6 дахь тив буюу мөсөн тивд ирлээ. Энд намрын сүүлч болж, агаарын хэм -10 орчим, нар биднээс улам холдсоор.	?
3	Салхи 38 м/с хүрч цасан шуургатай байна. Миний өвөлжих энэ станц үргэлж цас шуурч байдгаараа бусдаасаа онцлог. Өвөлдөө хасах 30-35 хэмээс илүү хүйтрэхгүй боловч салхины хүч их. Агаарын хэм хасах 35 хэм хүрэх үед ч хацар, хамар үлдэхгүй л шинжтэй юм	?

A purple, cloud-like shape with a soft, irregular border, centered on a white background. Inside the shape, the text "Анхаарал хандуулсанд баярлалаа." is written in a blue, sans-serif font.

Анхаарал хандуулсанд  
баярлалаа.